



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/191

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор цэвэр, дулааны шугам татах ажлын эхлэл (Булган сум 6 дугаар баг Залуус 8,12,13,14,15 дугаар гудамж) гүйцэтгэгчээр шалгарсан “Бурхууд” ХХК-тай 1,922,500,000 (нэг тэрбум есөн зуун хорин хоёр сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Бурхууд” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Т.Болдбаатар)-д даалгасугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгүүлж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010253

Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 16-ны/ний өдрийн  
А/191 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	33,382,532	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	33,382,532	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	16,691,266	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	3,004,428	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Очирсүрэн
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Очирсүрэн
8	Ажил гүйцэтгэх хугацаа	2026.05.01-2026.10.31 2027.05.01-2027.11.30	Ү.Бямбасүрэн

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 19-ны/ний өдрийн  
...1191 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн  
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Э.Жаргалцэцэг	Ү.Бямбасүрэн
2	Усан хангамж ариутгах татуургын инженер	Л.Баатархүү	
2	Дулааны инженер	Ч.Нямдэлэг	
3	ХАБЭА-н ажилтан	Н.Болдхүү	
Машин механизмын жагсаалт			
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Экскаватор	3696 УН	Ү.Бямбасүрэн
2	Автокран	8653 ОРА	
3	Ачааны автомашин	9265 ОРХ	

--o00o--